



ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ  
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРООНЫ  
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 01 сарын 31 өдөр

Дугаар 1/39

Улаанбаатар хот

Г Буудлага спортын Үндэсний шигшээ  
багийн бүрэлдэхүүн батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1 дэх заалт, 8.4 дэх хэсэг, Биеийн тамир, спортын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.7, 11 дүгээр зүйлийн 11.3.7, 11.3.9, 18 дугаар зүйлийн 18.3, 18.4, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэг, Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны даргын 2023 оны А/22 дугаар тушаалаар батлагдсан “Үндэсний шигшээ багийг бүрдүүлэх спортын төрлийг сонгох, санхүүжүүлэх журам”-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Буудлага спортын Үндэсний шигшээ багийн бүрэлдэхүүний нэрсийг хавсралтаар баталсугай.

2. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг ханган тус хуулийн 08 дугаар зүйлд заагдсан нээлттэй мэдээллийг байгууллагын цахим хуудсанд байршуулан мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллахыг Монголын Буудлага спортын холбоонд үүрэг болгосугай.


3. Батлагдсан бүрэлдэхүүн, орон тооны дагуу цалин, нийгмийн даатгалын шимтгэлийг сар бүр Буудлага спортын холбоонд шилжүүлэхийг Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн Ерөнхий нягтлан бодогч (А.Өнөрцэцэг)-д зөвшөөрсүгэй.

4. Цалин, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан, хувь хүний орлогын албан татварын тайланг улирал тутам хянаж, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллахыг Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс (Д.Цэрэнболд)-т, холбооны саналыг үндэслэн бүрэлдэхүүн хөдөлгөөнд тухай бүр өөрчлөлт оруулахыг Үндэсний шигшээ багийн бодлогын хэрэгжилтийн хэлтэс (Э.Билэгт)-т тус тус үүрэг болгосугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавин ажиллахыг Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтэс (Н.Батсүх)-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

О.БАТТУЛГА



142401120

Биеийн тамир, спортын улсын  
хорооны даргын 2024 оны.....  
дүгээр сарын 31.-ны өдрийн 139  
дугаар тушаалын хавсралт

БУУДЛАГА СПОРТЫН ҮНДЭСНИЙ ШИГШЭЭ  
БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

№	Овог	нэр	Үүрэг	Төрөл
1	Лхагва	Ундралбат	dasgaljuulagch	Гар буу
2	Жанчивдорж	Ганхуяг	dasgaljuulagch	Урт буу
3	Нянтай	Баяраа	тамирчин	Урт буу
4	Батбаяр	Эрхэмбаяр	тамирчин	Урт буу
5	Энхтувшин	Сайнхүү	тамирчин	Урт буу
6	Энхтайван	Даваахүү	тамирчин	Гар буу
7	Ширгал	Буянзаяа	тамирчин	Гар буу
8	Энхтайван	Бадамгарав	тамирчин	Гар буу
9	Ганхуяг	Нандинзаяа	тамирчин	Урт буу
10	Оюунбат	Есүгэн	тамирчин	Урт буу
11	Олзвойбаатар	Янжинлам	тамирчин	Урт буу
12	Төмөрчөдөр	Баярцэцэг	тамирчин	Гар буу
13	Отряд	Гүндэгмаа	тамирчин	Гар буу
14	Б. Цолмонбаатар	Анударь	тамирчин	Гар буу

--ооо--